

**ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаараа явууллаа.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 247 дугаар тогтоолоор салбар, байгууллагын хэмжээнд төрийн нууцад хамаарах 574 мэдээллийн жагсаалтыг баталсан бөгөөд уг жагсаалтад 2019-2024 онд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт, 2 удаа мэдээллийн жагсаалтаас хассан, 3 удаа өөрчлөлт оруулсан, 14 удаа нэмсэн тохиолдол байна. Төрийн нууцын жагсаалтыг Засгийн газрын шийдвэрээр баталснаар ард түмнээс сонгон байгуулсан төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын хяналт суларч, уг жагсаалтыг үндэслэлгүйгээр өргөжүүлэх нөхцөл бүрдэж байгаа тул “төрийн нууцыг хуулиар тогтоон хамгаалах” олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн төрийн нууцын жагсаалтыг хуулиар тусгайлан батлахаар боловсруулсан байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын “D.Parliament.mn” цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулахад Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН